

Энхийг дэмжих ажиллагаанд ОХУ-ын оролцоо ба онцлог

П.Отгонбаатар¹, Д.Майцэцэг¹

¹Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Энхийг дэмжих олон улсын судалгааны төв

Key words:

USSR, Russian Federation, foreign policy, peace support operations, Commonwealth of Independent States (CIS), Collective Security Treaty Organization (CSTO)

Abstract: Peacekeeping operations are a form of international cooperation implemented under the decisions of the United Nations (UN) Security Council or within the framework of relevant regional organizations and countries to ensure international and regional peace and security, halt armed conflicts, and eliminate their negative consequences. The Russian Federation actively participates in peacekeeping operations; however, some countries view this involvement critically. In other words, Russia's military actions in neighboring countries are not regarded as peacekeeping operations by those states. In some cases, they are even seen as steps driven by geopolitical interests. This article explores Russia's history of participation, its policies, and decisions regarding peacekeeping operations within the framework of the UN and regional security cooperation organizations.

Удиртгал

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд өнөөгийн байдлаар дэлхийн 120 гаруй улс оролцож, олон улсын аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах, зөрчилдөөнтэй бүс нутагт хууль, эрх зүйт засаглалыг сэргээх, сонгууль зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хүний эрхийг хамгаалах зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр чиглэлүүд нь энхийг дэмжих ажиллагаанд оролцогч улс орнуудын үндсэн үүрэг, чиглэл боловч нөгөө талаас улс орнууд геополитикийн болон олон улсын харилцаанд үзүүлэх стратегийн ач холбогдлын хувьд үнэлэн авч үздэг. Тиймээс энхийг дэмжих ажиллагааны оролцоог тухайн улсын олон улсын тавцанд эерэг “имиж” бүрдүүлэх, бүс нутгийн нөлөөгөө нэмэгдүүлэх, дипломат байр сууриа бэхжүүлэх нэгэн боломж гэж үзэх тал бий.

Манай хойд хөршийн хувьд энхийг дэмжих ажиллагаанд оролцох нь ОХУ-ын гадаад бодлогын гол хэсэг бөгөөд тус улсын өмнө тулгарч буй олон асуудлыг шийдвэрлэх стратегийн чухал хэрэгсэл. Иймээс ОХУ дэлхийн болон бүс нутгийн асуудлуудыг хамтран шийдвэрлэхэд идэвхтэй байр сууринаас хандаж НҮБ-ийн энхийг сахиулах ажиллагаанд оролцохоос гадна “Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг” (ТУХН), “Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага” (ХАБГБ)-ын хамтын зөвшилцлийн хүрээнд энхийг

дэмжих ажиллагааг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож байна¹. Нөгөөтээгүүр, ОХУ нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн орны хувьд тус зөвлөлөөс гаргасан тогтоол, шийдвэрт хориг тавих эрхтэй. Тиймээс тус улсыг зөрчилдөөн гарсан бүс нутагт НҮБ-ын оролцооны хэлбэрийг тодорхойлох, үйл явцыг аль нэг талын ашиг сонирхолд нийцүүлэхэд нөлөө үзүүлж чадах, эсвэл саад болж мэдэх чухал хүчин гэж улс орнууд үнэлдэг. Үүнээс үүдэн ОХУ-ын гадаад бодлого, байр суурь олон улсын анхаарлын төвд байсаар ирсэн.

1. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа ба ОХУ

Зөвлөлт холбоот улс (хуучин нэрээр) нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг олон улсын мөргөлдөөний тодорхой үе шатыг зохицуулах, тогтворжуулах арга хэрэгсэл гэж үздэг АНУ болон барууны орнуудын чиг хандлагыг төдийлөн дэмждэггүй байв. Дэлхийн улс орнуудын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсэх гол шалтгаан бол хоёр өөр капиталист болон социалист системийн зөрчил гэх ойлголт цэрэг, улс төрийн удирдлагын түвшинд байжээ. Гэсэн хэдий ч 1970-аад оны эхэн үед ЗХУ болон АНУ-ын харилцаа харьцангуй зөөлөрсөнтэй² холбоотойгоор НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд ажиглагч илгээх, санхүүжилтэд хэсэгчлэн оролцох саналыг зөвшөөрсөн байна³. Ийнхүү тус улсын НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсон эхний тохиолдол (1960 онд Конгод хэрэгжсэн UNUC ажиллагаанд хүнсний тусламж хүргэх агаарын тээвэрлэлтэд дэмжлэг үзүүлснийг эс тооцвол) одоогоос 53 жилийн өмнө буюу 1973 оны аравдугаар сард тохиосон бөгөөд Египет, Сири, Израиль улсуудын хооронд гал зогсоох гэрээг хянах зорилгоор Египет улс руу (UNEF II ажиллагаа) анхны цэргийн ажиглагчдын бүлгийг илгээж байжээ. Түүнээс хойш 1988 оныг хүртэл хэрэгжсэн НҮБ-ын бусад 10 гаруй энхийг сахиулах ажиллагаанд бодит оролцоо, дэмжлэг үзүүлээгүй байна⁴. Гэвч 1988-1991 оны хооронд,

¹ 1992 оноос ТУХМН, 2007 оноос ХАБГБ;

² 1967-1979 оны үеийг “*détente*” (фр.), “*разрядка напряжённости*” (орос.) буюу хурцадмал байдал намжих үе гэж олон улсад нэрлэдэг. АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсон ЗХУ-ын дотоод бодлого, нийгэм-улс төрийн тогтолцоог анхаарах асуудал биш, харин олон улсад чиглэсэн үйл ажиллагаа, хандлага нь илүү чухал ач холбогдолтой гэж үзэж байв. Мөн тухайн цаг үед зөвлөлтийн болон барууны орнуудын харилцаа ойртсон нь ЗХУ-АНУ харилцаанд нааштай өөрчлөлтүүдийг авчирчээ. Үүний үр дүнд 1972 оны тавдугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч нараас анх удаа Ричард Никсон Москвад албан ёсны айлчлал хийн “Стратегийн зэвсэглэл хязгаарлах тухай хэлэлцээ” (SALT)-г явуулжээ. Гэвч ЗХУ Афганистан руу цэргийн хүчээ оруулсны дараа харилцаа дахин хүйтэрсэн байна;

³ Брынкина, Яна Анатольевна. *Участие России в миротворческих операциях ООН: конец XX - начало XXI вв./диссертация*;

⁴ Зөвлөлт улс зэргэлдээ улс орнуудын нутаг дэвсгэр дээр, тухайлбал 1956 онд Будапешт, 1968 онд Прага, мөн 1979 онд Афганистанд энхийг сахиулах ажиллагаа явуулсан гэж ОХУ-ын судлаачид үздэг боловч үүнийг цэвэр улс төр, цэргийн зорилгоор хэрэгжсэн гэж АНУ болон барууны орнууд шүүмжилдэг.

ЗХУ задрахын өмнөхөн, тус улс нь Барууны орнуудад оросын талаарх төлөвшсөн “Энх тайван, аюулгүй байдалд заналхийлэгч” гэсэн ойлголтыг өөрчлөх зорилго дэвшүүлж эхэлсэн. Энэ хүрээнд тухайн хугацаанд шинээр эхлүүлсэн НҮБ-ын есөн ажиллагааны тавд нь идэвхтэй оролцжээ. Үүнд:

- 1988 он: Иран-Иракийн UNIMOG ажиллагаанд ажиглагчдын бүлэгт оролцож буй Канадын цэргүүдэд агаарын тээврийн дэмжлэг үзүүлсэн;
- 1989 он: Намибийн UNTAG ажиллагааны шилжилтийн тусламжийн бүлэгт сонгуулийн ажиглагч илгээсэн;
- 1991 он: Ирак-Кувейтын хилийн бүсэд хэрэгжсэн UNIKOM ажиллагаанд ажиглагч томилсон;
- 1991 он: Баруун Сахарт явагдсан санал хураалтын MINURSO ажиллагаанд ажиглагчид оролцуулсан;
- 1991 он: Камбожид хэрэгжсэн UNTAC ажиллагаанд цэргийн холбооны ажилтнууд илгээсэн зэрэг ажиллагаа багтаж байна.

Ийнхүү дөч гаруй жилийн хугацаанд олон улсын энхийг сахиулах үйл ажиллагааг дутуу үнэлж байснаа ойлгон дэлхийн геополитикийн нөхцөл байдалд гарч буй өөрчлөлтөд бодит үнэлгээ хийж чадсанаар энхийг дэмжих ажиллагаанд хандах хандлага, арга барилаа эрс өөрчилсөн байдаг. 1991 оноос эхлэн ЗХУ-ын олон улсын хууль эрх зүйн орчинд хүлээсэн үүргийг ОХУ үргэлжлүүлэн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цагдаа, цэргийн алба хаагчдаа илгээсэн юм. 1992 оноос Оросын цэргийн ажиглагчид Югослав, Камбож, Мозамбикт, 1994 оноос Руанда, Гүржид, 1995 оноос Анголд, 1997 оноос Гватемалад, 1998 оноос Сьерра-Леонд, 1999 оноос Зүүн Тимор болон Бүгд найрамдах ардчилсан Конгод байрлаж ажилласан. ОХУ-ын 1992 оноос 2024 оныг хүртэлх хугацаанд оролцсон энхийг сахиулах ажиллагааг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. ОХУ-ын НҮБ-ийн энхийг сахиулах ажиллагаа (1992 -2024 он)

№	Он	Зөрчил үүссэн газар орон	Тайлбар
1	1992-1997	Югослав: Сараево	ОХУ-ын 629 дүгээр тусгай батальон Сараево хотод ЭСА-нд оролцсон.
2	1995.11	Югослав: Босни, Герцеговин	1340 хүний бүрэлдэхүүнтэй ОХУ-ын тусгай агаарын десантын бригад байгуулагдаж, олон улсын хүчний бүрэлдэхүүнд багтан хуучин Югославын бүгд найрамдах улсууд дахь зэвсэгт мөргөлдөөнийг зогсоох үйл ажиллагаанд оролцсон.
3	1995-1996	Ангол	Оросын цэргийн нисдэг тэрэгний нисгэгчид Ангол улсад өрнөж байсан иргэний


			дайны үеэр НҮБ-ын ажиглагчийн багийн бүрэлдэхүүнд ажилласан.
4	1999.06-2003.07	Косово	Холбооны Зөвлөлийн шийдвэрээр Косово, Метохид 3600 орос энхийг сахиулагч илгээгдсэн.
5	2000.06-2005.09	Сьерра-Леон	Оросын 100 гаруй цэргийн нисгэгч НҮБ-ын ажиллагаанд агаарын тээврийн дэмжлэг үзүүлсэн.
6	2004.06-2006.12	Бурунди	ОХУ-ын Зэвсэгт хүчний 10 орчим алба хаагчид Бурундид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсон.
7	2006 оны 4 дүгээр сараас 2012 оны 3 дугаар сар хүртэл	Судан болон Өмнөд Судан	НҮБ-ын энхийг сахиулах хүчний бүрэлдэхүүнд 120 орчим хүний бүрэлдэхүүнтэй, Ми-8 загварын дөрвөн нисдэг тэрэг бүхий Оросын нисэх хүчний баг ажилласан.
8	2008.09-2010.02	Бүгд Найрамдах Чад Улс, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс	ОХУ-ын Зэвсэгт хүчний 100 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй анги Европын Холбооны ажиллагаанд оролцож, Бүгд Найрамдах Чад болон Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад НҮБ-ын оролцоог дэмжих үүрэг гүйцэтгэсэн.
9	2021-2024	БНАКУ, Баруун Сахар, ТАБНУ, Косово, Кипр, Ойрхи Дорнод Өмнөд Судан, Бүгд Найрамдах Судан	НҮБ-ын peacekeeping.un.org сайтад тэмдэглэснээр 2024 оны 8 дугаар сарын байдлаар НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагаанд тус улсаас цагдаа 17, ажиллагааны офицер - 25, штабын офицер - 43 нийт 85 орчим алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цэрэг илгээгч улсын жагсаалтад ороогүй байна.

Өнөөгийн байдлаар ОХУ нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны жил бүрийн төсвийг бүрдүүлэгч орнуудын жагсаалтад 10 дугаарт бичигдэж байна. Тухайлбал, 2024-2025 оны НҮБ-ын санхүүгийн жилд батлагдсан 5,6 тэрбум ам.долларын 2,29 хувийг буюу ойролцоогоор 130 сая ам.долларыг бүрдүүлжээ⁵. Харин жагсаалтын эхэнд бичигддэг АНУ болон БНХАУ нь тус бүр тэрбум ам.доллараас давсан хөрөнгө хандивласан байна. Оросын ЭСА-ны оролцооны бас нэг хэлбэр бол цэрэг, цагдаагийн бүрэлдэхүүн илгээх явдал. Гэсэн хэдий ч энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй бодит тоо хэмжээ нь харьцангуй бага байгаа буюу цэрэг илгээгч орнуудын жагсаалтад 62 дугаарт бичигдэж байгаа нь тус улсын олон улсын тавцан дах байр суурь болон Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүний статусыг харж

⁵ НҮБ-ийн албан ёсны цахим хуудас: <https://peacekeeping.un.org/en/contributors>;

үзвэл харьцангуй доогуур үзүүлэлт гэж шинжээчид үзжээ⁶.

*График 1. ОХУ-ын энхийг сахиулах ажиллагааны оролцоо, хүн/тоо⁷
(2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар)*



Тайлбар:

UNMISS - НҮБ-ын Өмнөд Суданд хэрэгжүүлж буй энхийг сахиулах ажиллагаа;

MONUSCO - НҮБ-аас Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад хэрэгжүүлж буй тогтворжуулах ажиллагаа;

MINUSCA - НҮБ-ын Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад хэрэгжүүлж буй олон талт, тогтворжуулах ажиллагаа;

MINURSO - НҮБ-ын Баруун Сахарт бүх нийтийн санал асуулга явуулах зорилго бүхий энхийг сахиулах ажиллагаа;

UNFICYP - НҮБ-ын Кипр улсад хэрэгжүүлж буй энхийг сахиулах ажиллагаа;

UNTSO - НҮБ-ын Ойрх Дорнодод гал зогсоох гэрээний хэрэгжилтийг хянах байгууллага;

UNISFA - НҮБ-ын Абьей дэх түр хугацааны аюулгүй байдлын ажиллагаа.

График 1-ээс харахад ОХУ нь 2024 оны байдлаар Өмнөд Судан, Конго, Төв Африкийн бүгд найрамдах улс, Баруун Сахар, Кипр зэрэг улсуудад явуулж буй НҮБ-ын долоон ажиллагаанд нийт 54 цэрэг, цагдаагийн алба хаагчаа илгээжээ.

2. ОХУ-ын Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг болон Хамтын ажиллагааны гэрээний байгууллагуудын зөвшилцлийн хүрээнд хэрэгжүүлж буй энхийг дэмжих ажиллагаа

ОХУ нь зөвхөн НҮБ-ын хэмжээнд бус, бүс нутгийн түвшинд ч энхийг дэмжих ажиллагааг идэвхжүүлэх санаачилга гаргаж ирсэн. Тухайлбал, Оросын цэргийн алба хаагчид 1992 оноос Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн (ТУХН), 2007 оноос Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага (ХАБГБ)-ын энхийг дэмжих хамтарсан хүчний бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэж иржээ.

Энхийг дэмжих тухай үзэл баримтлал хуучин ЗХУ-д бараг байгаагүй,

⁶ Миротворческая деятельность и вопрос статуса России. https://russiancouncil.ru/analytics-and-comments/interview/mirotvorcheskaya-deyatelnost-i-vopros-statusa-rossii/?sphrase_id=196185345;

⁷ НҮБ-ийн албан ёсны цахим хуудас: <https://peacekeeping.un.org/en/troop-and-police-contributors>;

ийм төрлийн үйл хэргийг зохицуулах ямар нэг хууль, эрх зүйн зохицуулалтгүй байсан тул ЗХУ-ын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид олон улсын энхийг дэмжих ажиллагаанд *зэвсэгт халдлагаас хамгаалахад чиглэсэн хамтын ажиллагаа* гэх ойлголтын хүрээнд оролцдог байсан. Иймээс Зөвлөлтийн дараах орон зайд «энхийг дэмжих ажиллагаа» нь харьцангуй шинэ зүйл байсан хэдий ч 1992 оны 3 дугаар сарын 20-нд ТУХН-ийн орнууд болох ОХУ, Казахстан, Киргиз, Узбекистан, Тажикистан улсууд “Цэргийн ажиглагчдын бүлэг болон Энхийг дэмжих хамтын хүчний тухай» гэрээ, 1993 оны 9 дүгээр сарын 24-нд «Энхийг дэмжих хамтын хүчний гэрээ»-г байгуулжээ. Үүний дараа, 1996 онд “ТУХН-ийн гишүүн орнуудын нутаг дэвсгэр дээрх зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, зохицуулах үзэл баримтлал»-ыг баталсан байна. Эдгээр эрх зүйн баримт бичгийн хүрээнд 1993 оны 1 дүгээр сарын 22-нд Тажикистан дахь Оросын хилийн албыг Казахстан, Киргиз, Узбекистаны нэмэлт цэргийн хүчээр бэхжүүлэх болон Тажикистан - Абхаз дахь энхийг сахиулах ажиллагааг эхлүүлэх шийдвэрүүдийг гаргаж байв. Улмаар ТУХН-ын улс, орнуудын 1992 оны 5 дугаар сарын 15-нд Ташкент хотноо байгуулсан «Хамтын аюулгүй байдлын гэрээ» нь Армени, Казахстан, Киргиз, Орос, Тажикистан, Узбекистан улсуудыг нэгтгэн ХАБГБ-ыг байгуулах суурийг тавьжээ.

ХАБГБ-ын энхийг дэмжих хүчийг тус байгууллагын гишүүн орнуудын 2007 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн гэрээ болон 2011 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Энхийг дэмжих хүчийг байршуулах тухай протокол”-ыг үндэслэн байгуулсан. Энэ хүчин нь гишүүн орнуудын цэрэг, цагдаагийн болон энгийн алба хаагчдын бүрэлдэхүүнтэй энхийг дэмжихийн анги, салбаруудаас бүрддэг. ХАБГБ-ын бүтцэдээ дараах хоёр гол хүчнийг багтаадаг. Үүнд:

- Төв Азийн бүс нутгийн Хамтын ажиллагааны түргэн байрлах хүчин (Коллективные силы быстрого развёртывания - КСБР) - 4,0 мянга орчим хүний бүрэлдэхүүнтэй. Орос, Казахстан, Киргиз, Тажикистаны цэргийн алба хаагчдаас бүрддэг;
- Шуурхай хариу арга хэмжээ авах хамтын ажиллагааны хүчин (Коллективные силы оперативного реагирования - КСОР) - 17,0 мянга орчим хүний бүрэлдэхүүнтэй⁸;

Эдгээр хүчний хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор жил бүр ХАБГБ-ын хүрээнд энхийг дэмжих чиглэлээр олон талт дадлага, сургуулиудыг зохион байгуулдаг.

Эдгээр гэрээний байгууллагуудын зөвшилцлийн хүрээнд 1992 онд Орос, Гүрж, Өмнөд болон Хойд Осетийн удирдагчдын хооронд байгуулсан Сочигийн гэрээ буюу “Хурцадмал байдал үүссэн газар оронд тогтвортой

⁸ ОДКБ: зона коллективной безопасности. <https://armystandard.ru/news/20185171236-ХНУ08.html>;

байдлыг хангах тухай” санамж бичгийн дагуу энхийг дэмжих ажиллагааг Таджикстан - Гүрж болон Приднестровьед амжилттай хэрэгжүүлсэн. 1994 онд ОХУ нь Армени болон Азербайжаны хоорондох Уулын Карабахын зэвсэгт мөргөлдөөнийг зогсоохын тулд гал зогсоох гэрээ байгуулах санаачилга гаргаж, тус бүс нутагт энх тайвныг тогтоох үйл хэрэгт идэвхтэй оролцсон. Ингэснээр ОХУ нь Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын дэргэдэх Минскийн бүлгийн⁹ гол хэлэлцэгч орон болохын зэрэгцээ Армени болон Азербайжаны өндөр түвшний яриа хэлэлцээнд зуучлагчийн үүрэг гүйцэтгэсэн. 2014-2015 оны Минскийн гэрээний дагуу ОХУ нь Украины дотоод мөргөлдөөн, ялангуяа Донецк, Луганскын (Новороссия) бүс нутгийн асуудлыг энхийн замаар шийдвэрлэхийн төлөө идэвхтэй хүчин чармайлт гаргаж ажилласан байна.

Хүснэгт 2. ТУХН, ХАБНГ-ийн хэлэлцээрийн хүрээнд оролцсон энхийг дэмжих ажиллагаа

№	Он	Зөрчил үүссэн газар орон	Үр дүн
1	1992 - 2008	Гүрж-Осетийн мөргөлдөөн	Оросын Ерөнхийлөгч Борис Ельцин, Гүржийн Ерөнхийлөгч Эдуард Шеварднадзе нар Сочигийн хэлэлцээрийг байгуулж энхийг сахиулах холимог хүчнийг байршуулсан. Уг ажиллагаанд Гүрж, Өмнөд Осет, Оросын энхийг сахиулагчид оролцсон бөгөөд Оросын талаас Хойд Кавказын цэргийн тойргийн 58 дугаар армийн анги нэгтгэлүүд үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү ажиллагааны явцад Оросын 46 цэрэг амь үрэгдсэн бөгөөд 2008 онд Гүрж Өмнөд Осет руу довтолсны дараа ажиллагааг зогсоосон.
2	1992 оны 7 дугаар сараас	Приднестровийн зэвсэгт мөргөлдөөн	1992 оны долоодугаар сард Орос, Молдав улс Приднестровийн зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах гэрээ байгуулснаар тус бүс нутагт 6 батальон буюу 3,000 гаруй орос цэргийг байршуулсан. Энэ мөргөлдөөн одоог хүртэл үргэлжилсээр байна. Өнөөдөр Приднестровид Молдавийн энхийг сахиулагчдаас гадна 400 гаруй оросын алба хаагчид байрлаж буй бөгөөд Оросын армийн нийт 21 алба хаагч амь үрэгджээ.

⁹ Минскийн бүлэг нь Карабахын мөргөлдөөнийг энхийн замаар шийдвэрлэхээр зорилго бүхий ЕАБХАБ-ын гишүүн орнуудын бүлэг юм. Минскийн бүлгийг АНУ, ОХУ, БНФУ нар хамтран удирдаж байсан;

3	1993 оны 9 дүгээр сар	Тажикстан	ТУХН-ийн эвслийн энхийг сахиулах хүчнийг иргэний дайн болж байсан Тажикстаны байдлыг хэвийн болгох зорилгоор байгуулсан.
4	1994 оны 6 дугаар сар	Гүрж-Абхазын мөргөлдөөн	ТУХН-ийн Төрийн тэргүүн нарын зөвлөлийн шийдвэрээр Оросын 1.8 мянга гаруй энхийг сахиулагчийг Абхаз руу илгээв. Энэ ажиллагааг эхлүүлэх үндэс нь Гүрж-Абхазын мөргөлдөөнд оролцогч талууд Москвад гарын үсэг зурсан “Гал зогсоож, хүч тусгаарлах тухай гэрээ” байв.
5	2008 оны 8 дугаар сар	Гүрж	Өмнөд Осетийн энгийн иргэд болон Оросын энхийг сахиулагчдын эсрэг түрэмгийлсний хариуд тус улс цэргийн ажиллагаа явуулсан
6	2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс	Уулын Карабах	Орос, Азербайжан, Арменийн удирдагчдын тохиролцсоны дагуу Оросын 1960 цэргийн албан хаагчийг мөргөлдөөний бүс рүү илгээсэн байна.
7	2022 онд	Казахстан	2022 оны нэгдүгээр сарын эхээр Казахстан улсад эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөж төрийн эргэлт хийх оролдлогын түвшинд хүрсэн. Нөхцөл байдал хүндрэхэд ерөнхийлөгч К.Токаев ХАБГБ-ын энхийг сахиулагчдыг оруулах шийдвэр гаргасан. ХАБГБ-ын хамтарсан хүчийг оролцуулахад ОХУ голлох үүрэгтэй оролцсон ба тус улсын стратегийн объектууд, төрийн байгууллагуудыг хамгаалах, эсэргүүцлийг дарахад хүчний байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор агаарын десантын цэргээ оруулсан байна.

3. Орос улсын энхийг дэмжих ажиллагааны үзэл баримтлал

ОХУ-ын 2015 онд баталсан Үндэсний аюулгүй байдлын стратегийн бичигт энхийг дэмжих ажиллагааг зөрчил, мөргөлдөөнийг зохицуулах нэгэн чухал институц хэмээн үзэж, түүнийг улам бүр бэхжүүлэх шаардлагатайг онцолсон бол Аюулгүй байдлын тухай хуульдаа энхийг дэмжих ажиллагаа нь зөрчил, маргааныг шийдвэрлэх гол хэрэгсэл хэмээн тодорхойлжээ. 2016 оны Гадаад бодлогын үзэл баримтлалд “энхийг дэмжих ажиллагаа нь зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах, хямралын дараах нөхцөлд төрийн институц, тогтолцоог сэргээх үр дүнтэй хэрэгсэл” гэж тодорхойлсон байдаг.

Гэхдээ ОХУ-ын энхийг дэмжих ажиллагааны үзэл баримтлал нь АНУ болон барууны орнуудын “хүний эрх”-д тулгуурласан үзэл баримтлалаас зөрүүтэй байдаг. Энэ тал дээр БНХАУ-ын “улс орнуудын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх”, “хүлээн авагч улсын

зөвшөөрөл”-ийг тэргүүн ээлжид тавих ёстой гэсэн зарчимтай төстэй боловч зарим талаараа ялгаатай. Тухайлбал, Хятад улс аливаа улсад эдийн засгийн таатай нөхцөл бүрэлдэж байж, энх тайван тогтоно хэмээн харж байгаа бол Орос улс аливаа улсын гадаад болон дотоод аюулгүй орчныг хангаж чадвал тухайн улс оронд хөгжил, дэвшил, нийгмийн тогтвортой байдал үүснэ гэж үздэг. Энэ байр сууриа ч НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хэлэлцүүлэг дээр цөөнгүй удаа илэрхийлсэн байдаг.

Харин барууны судлаачид, Оросын энэ чиг хандлагыг дараах байдлаар шүүмжилдэг. “Нэгдүгээрт, Орос улсад энх тайвныг бэхжүүлэх талаар сайтар боловсруулсан бодлогын бичиг баримт үгүй бөгөөд “мироостроительство” (энхийг тогтоох) гэх нэр томъёог түлхүү ашигладаг ч энэ нь цогц системтэй ойлголт биш. Хоёрдугаарт, ардчилсан тогтолцоо, иргэний нийгмийн тогтвортой байдал, хүний эрхийн талаар төдийлөн анхаарал хандуулдаггүй. Тухайлбал, Орос улс энх тайван, аюулгүй байдлыг тогтоох талаар НҮБ-ээс явуулж буй бодлого, шийдвэрийг “тусгаар улсуудын бүрэн эрхэд халдаж байна” гэж мэдэгдэж байсан удаатай. Гуравдугаарт, Оросын байр суурь яриа, хэлэлцээрийн түвшинд болон бодит байдал хоёр ихээхэн зөрүүтэй. Түүнчлэн ОХУ нь НҮБ-ын энхийг дэмжих бүрэн хэмжээний хөтөлбөр (хөгжлийн хөтөлбөр, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, мөргөлдөөний дараах сэргээн босголт гэх мэт) -т анхаарал бага хандуулж байна¹⁰ гэж тэд үзжээ.

Дүгнэлт

ОХУ-ын НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны оролцоо харьцангуй бага байгаа боловч олон улсад хэрэгжүүлж буй цэргийн ажиллагааг авч үзвэл аливаа зөрчил, мөргөлдөөний бүхий л үе шатанд гол тоглогч хэвээр байна. Тэд хөрш зэргэлдээ орнууд төдийгүй Африк, Ойрх Дорнодод цэргийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа¹¹. ОХУ-ын хувьд дэлхийн халуун цэгүүдэд үүссэн хямралыг зохицуулахад идэвхтэй байр суурь эзэлж буй нь нэг талаас тус улсын нэр хүндийг олон улсын тавцанд өсгөх, цэрэг, армийнхаа сургалт, бэлтгэлийг хангах, батлан хамгаалахын хүчин чадлыг нэмэгдүүлэх, улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зэрэг ач холбогдолтой боловч нөгөө талаас, АНУ болон барууны орнуудын шүүмжлэлийг ихээр дагуулдаг хэвээр байна. Тухайлбал, ОХУ-ын Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг болон Хамтын ажиллагааны гэрээний байгууллагуудын зөвшилцлийн хүрээнд хэрэгжүүлж буй ажиллагааг “хүч хэрэглэсэн эвлэрүүлэн зуучлах хандлага” (coercive mediation approach) гэж баруун судлаачид томъёолоод байна. Ийнхүү олон улсад ОХУ-ын энхийг

¹⁰ Stockholm international peace research institute. China, Russia and the future of peacebuilding. 2024. [www.https://www.sipri.org/](https://www.sipri.org/)

¹¹ Участие России в миротворческих операциях. 2022/01. <https://www.kommersant.ru/>

дэмжих ажиллагааны арга барилын талаар хандлага, ойлголтын зөрчил байгаа нь улс орнуудын харилцаанд ч сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болж байгаагийн илэрхийлэл хэмээн үзэж байна.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. Flemming Splidsboel Hansen. The Russian approach to peacekeeping. International Affairs, Volume 100, Issue 3, May 2024, Pages 1023 - 1042, <https://doi.org/10.1093/ia/iiac072>;
2. Губарь А. Н. Роль России в урегулировании острой фазы приднестровского конфликта (1990—1992);
3. Современная научная мысль. 2022. № 5. С. 202—207. <https://doi.org/10.24412/2308-264X-2022-5-202-207>;
4. Дергачев А. Ю. Российская Федерация и урегулирование конфликтов на постсоветском пространстве (эволюция концептуальных основ и миротворческой практики) // Гуманитарные проблемы военного дела. 2018. № 1. С. 23—28;
5. Брынкина, Яна Анатольевна. Участие России в миротворческих операциях ООН : конец XX - начало XXI вв. :диссертация;
6. Journal of Advanced Military Studies. 2022. Vol. 13, Special Issue. P. 168—188. <https://doi.org/10.21140/mcu.j.2022SIstratcul010>;
7. Rotaru V. Change or Continuity in Russia’s Strategy towards Secessionist Regions;
8. Участие России в миротворческих операциях. 2022/01. <https://www.kommersant.ru>;
9. United Nations. (n.d.). United Nations Charter (full text). United Nations. <https://www.un.org/en/about-us/un-charter/fulltext>;
10. ОДКБ: зона коллективной безопасности. <https://armystandard.ru/news/20185171236-ХНУ08.html>;
11. Миротворческая деятельность и вопрос статуса России. https://russiancouncil.ru/analytics-and-comments/interview/mirotvorcheskaya-deyatelnost-i-vopros-statusa-rossii/?sphrase_id=196185345;